

АНУ: САНХҮҮГИЙН ХЯМРАЛЫГ ДАВАН ТУУЛАХ БОДЛОГО, ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН

*Т.Бат-Амгалан**

АНУ-ын Ерөнхийлөгч Барак Обама Америк төдийгүй дэлхий нийтийг хамарсан санхүүгийн хямрал нүүрлэсэн хүнд цаг үед улс орноо эдийн засаг, гадаад харилцаа, аюулгүй байдлын хувьд улам хүчирхэг гүрэн хэвээр байлгаж, ард түмнээ ажилгүйдлээс аврах итгэл найдвар хүлээн сонгогдсон ерөнхийлөгч билээ. Б.Обама улс орныхоо өмнө тулгамдсан асуудлуудыг шийдвэрлэх ажлаа санхүүгийн хямралыг богино хугацаанд гэтлэн давах цогц бодлого явуулахаас эхэлсэн. Санхүүгийн хямралын учир шалтгааны талаар хэлсэн үгэндээ: “Өнөөгийн санхүүгийн хямрал нь олон жилийн турш явж ирсэн хариуцлагагүй байдлын бодит үр дагавар бөгөөд энэ нь улсын болон хувийн секторын аль алинд нь хамаатай. Цаашид бид санхүүгийн хямралын олон урхагтай тулгарах тул юуны өмнө одоо л бид хариуцлага, ил тод байдлын эх суурийг тавих хэрэгтэй” гэж мэдэгдэж байлаа.

Ерөнхийлөгч Барак Обама үүрэгт ажлаа авснаас хойшхи хугацаанд улс орныхоо эдийн засгийн уналтыг сэргээн босгоход хамгийн их анхаарал тавьж, энэ чиглэлээрхи хэд хэдэн хууль тогтоомжинд өөрчлөлт оруулж, ажилчид ихээхэн тоогоор ажилладаг үйлдвэрлэл үйлчилгээний салбаруудад нэмж хөрөнгө оруулалт хийх замаар ажилгүйдлийг бууруулах иж бүрэн цогц төлөвлөгөө боловсруулсан билээ.

Энэхүү төлөвлөгөөний гол зорилт нь орон тооны цомхотголд орж ажлын байраа алдсан олон зуун мянган ажилчдыг буцааж ажилд нь оруулах, ажлын байр шинээр бий болгох, ажилчидаа цомхотгохоос өөр аргагүй болсон жижиг, дунд бизнес эрхлэгчдийг дэмжихийн зэрэгцээ эрүүл мэнд, боловсрол, эрчим хүч, дэд бүтцийн салбарт урт хугацааны нэмэлт хөрөнгө оруулалт хийхэд оршиж байна. Уг төлөвлөгөөний дагуу эхний 2 жилийн дотор 3.5 сая ажлын байрыг бий болгох буюу хадгалж үлдэх зорилт тавьсан байна.

2009 оны 11 сарын 1-ний байдлаархи статистикийн тоо баримтаас үзэхэд 640,329 ажлын байрыг шинээр бий болгосон буюу хадгалж үлдсэн байна.

Обамагийн шинээр бий болгосон буюу хадгалж үлдсэн ажлын байр аж үйлдвэрийн гол бүс нутаг болох томоохон 10 муж улсуудад хэрхэн хэрэгжиж, ямар үр дүнд хүрээд байгааг дараах хүснэгтээс үзнэ үү.

* Т.Бат-Амгалан - ОУСХ-ийн эрдэм шинжилгээний ажилтан

Шинээр бий болгосон буюу хадгалж үлдсэн ажлын байр, ажилгүйдлийг бууруулсан хувь хэмжээ

| | Муж | Ажлын байр | Ажилгүйдлийг бууруулсан хувь |
|----|----------------|------------|------------------------------|
| 1 | California | 110185.36 | 12.2% |
| 2 | New York | 40620.04 | 8.9% |
| 3 | Washington | 34517.13 | 9.3% |
| 4 | Florida | 29320.78 | 11% |
| 5 | North Carolina | 28,073.32 | 10.9% |
| 6 | Georgia | 24,681.1 | 10.1% |
| 7 | Illinois | 24,447.55 | 10.6% |
| 8 | New Jersey | 24,108.81 | 9.8% |
| 9 | Michigan | 22,513.86 | 15.3% |
| 10 | Texas | 19,571.84 | 8.2% |

Эх сурвалж: www.recovery.gov

Обамагийн эдийн засгийн уналт, санхүүгийн хямралын эсрэг барьж буй бодлогод санхүүгийн зах зээлийг тогтворжуулах асуудал хамгийн чухал байр суурь эзэлж байна. Санхүүгийн зах зээл болон банк санхүүгийн байгууллагуудын үйл ажиллагааны доголдол, хариуцлагагүй байдал америкийн сая сая ажилчид, тэдний гэр бүлд маш хүндээр тусч, асар их гарз хохирол учруулсан билээ. Ажлын байраа алдсан зарим нь энэ хүндрэлийн улмаас гэр бүлээ хүйс тэмтэрэх хүртэл сэтгэл санааны гүн хямралд орсныг бид мэдэх билээ.

Ерөнхийлөгч Обама мөнгөний M1, M2 урсгалыг тогтворжуулах, түүний тэнцвэрийг хангахын тулд ихээхэн хүчин чармайлт тавин ажиллаж байна. Банк санхүүгийн секторт явуулж буй эрс шинэчлэлийн бодлого үйл ажиллагааны үр дүнд жижиг дунд бизнес эрхлэгчид зээлэнд хамрагдаж үйлдэрлэл, үйлчилгээгээ хэвийн явуулах таатай боломж бүрдэж, ажлын байраа хадгалж үлдсэн төдийгүй бараа бүтээгдэхүүнээ зах зээлд дахин нийлүүлэх болов. Энэ хэрээр эрэлт нийлүүлэлтийн зохистой харьцаа бий болж хэрэглэгчдийн худалдан авах чадвар аажмаар сэргэж эхэллээ. Энэ дашрамд тэмдэглэхэд АНУ-ын бизнесийн 99 хувь нь 500-аас доош ажилчид бүхий жижиг, дунд бизнесийнхэн Америкийн эдийн засгийг авч явдаг. Тийм учраас жижиг, дунд бизнес АНУ-ын эдийн засгийн хөтлөгч хүчтэй хөдөлгүүр нь гэж үздэг. Жижиг дунд бизнес эрхлэгчид америкийн ажлын байрны тал орчим хувийг хангаж байдаг. Сүүлийн 10 жилд шинээр бий болсон ажлын байрны 70 хувийг дангаараа жижиг бизнесийн салбар эзэлж байна. Өнөөдөр Америкт олон зуун мянган бизнес эрхлэгчид өөрийн хүссэн хэмжээнд бизнесээ өргөжүүлэх хэмжээний хөрөнгийн хуримтлал бүрдүүлж чадахгүй байна. Үйлдвэрлэл явуулах, өргөжүүлэх шинэ шинэ санаа мөрөөдөл болох нь энүүхэнд. Гол саад бэрхшээл мөнөөх л зээлийн хязгаарлалтын шугам, санхүүгийн хямралын уршигт үр дагавар юм. Бидний сайн мэдэх SBA буюу жижиг бизнесийг удирдах төрийн байгууллага жил бүр тэдэнд зориулж 20 тэрбум ам.долларын зээлд баталгаа олгодог байлаа. Гэвч энэ тоо

санхүүгийн хямралын улмаас нэг дахин буурч 10 тэрбум ам.доллар болсон. Найдвартай зээлдэгч нар ч өнөөдөр зээл авч чадахгүй байдалд хүргэж байгаа нь улс орны хэмжээнд жижиг бизнесийнхэний үйлдэрлэлийн өсөлтийг сааруулж, цөөн тооны ажилчидтай, өртөг өндөртэй, зээлэндээ таарсан, үнэтэй бүтээгдэхүүн үйлдвэрлэхээс аргагүй байдалд хүргэж байгаа нь эдийн засгийн сэргэлтийг удаашируулж буй нэгэн “чөтгөрийн тойрог” болоод байгаа юм. Америкийн жижиг бизнесийн салбар нь дэлхийн эдийн засагт энэ орон тэргүүлэх үүрэг гүйцэтгэхэд шийдвэрлэх үүрэг гүйцэтгэдэг гэж шинжээчид үздэг.

Ерөнхийлөгч Обама саяхан жижиг бизнесийн тухай хэвлэлийн бага хурал дээр хэлсэн үгэндээ: Бидний өнөөгийн болон ирээдүйн сайн сайхан байдал америкийн жижиг бизнес, түүнийг эрхлэгчдийн ололт амжилтаас хамаарна. Тиймээс ч манай засаглал тэдний өмнөөс эрчимтэй арга хэмжээ авч эхэлж байгаа гэж хэлсэн билээ. Энэ үгийн биелэл дээрх дурдсан Америкийн сэргэлт, нэмэлт хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний баримт бичигт чухал байр суурь эзэлж орсон байна.

Обамагийн төлөвлөгөөний хүрээнд жижиг бизнес эрхлэгчдийн татварыг бууруулах, жижиг бизнесийн секторт хөрөнгө оруулалт хийхийг дэмжсэн тохиолдолд татварын урамшуулал олгох зэрэг багц арга хэмжээнүүд оржээ. Обама жижиг бизнес эрхлэгчдэд зориулан 2009 онд 15 тэрбум ам.долларын зээлийг банк, санхүүгийн байгууллагуудаар дамжуулан олгох шийдвэр гаргасан явдал юм. Обамагийн энэ шийдвэрийн үр дүн шууд харагдахгүй ч ирээдүйд үр дүнгээ өгөх маш чухал шийдвэр болсон гэж америкчууд талархан хүлээж авсан билээ.

Эцэст нь хэлэхэд жижиг дунд бизнес эрхлэгчдийгээ дэмжиж чадсан улс орон ядуурлаас ангижирч өсөлт хөгжлийн замд орсон туршлага хаа сайгүй л байгаа билээ.

Манай орны хувьд жижиг дунд үйлдвэрлэл, бизнесийг хөгжүүлэх үүрэг зорилго бүхий төрийн болон төрийн бус байгууллагууд, олон улсын хэд хэдэн байгууллага үйл ажиллагаа явуулж энэ талаар багагүй зүйл хийж зарим нааштай үр дүнд хүрч байгаа хэдий ч жижиг дунд үйлдвэрлэл, бизнесийн үйл ажиллагаа тогтворжоогүй, төрөөс хэрэгжүүлж буй бодлого, хөтөлбөр, арга хэмжээний үр дүн төдийлөн хангалтгүй байгаа нь уг асуудлыг шинэ шатанд авч үзэх шаардлага тулгарч байгааг харуулж байна.

Ашигласан эх сурвалж

1. Info USA Year book 2009
2. Small Business Administration (SBA) <http://www.sba.gov/>
3. <http://www.whitehouse.gov>
4. <http://www.recovery.org>
5. <http://www.BarackObama.com>
6. <http://www.forbes.com>
7. <http://www.entrepreneur.com>